



**МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ /Усны нөөцийг бохирдлоос
хамгаалах дүрэм/**

1997 оны 10 дугаар сарын 21-ний
өдөр

Улаанбаатар хот

Дугаар 143/А/352

Усны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм"-ийг хавсралт 1, "Унд ахуйн зориулалттай усны объектын усны чанарын норм, шаардлага"-ыг хавсралт 2, "Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын норм"-ыг хавсралт 3, "Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын тодорхойлолт"-ыг хавсралт 4, "Унд ахуйн ус ашиглалтын зориулалттай усны объектод байх хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ"-г хавсралт 5-аар тус тус баталсугай.

2. Дүрмийг хавсралтын хамт 1997 оны 10 дугаар сард багтаан аймаг нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах ажлыг Байгаль хамгаалах Алба (С.Банзрагч), Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын Алба (Н.Сайжаа)-д даалгасугай.

3. Дүрмийг шинэчлэн баталсантай холбогдуулан БОХЯ, ЭХЯ-ны сайдын 1989 оны "Дүрэм, норм батлах тухай" хамтарсан 68/А/61 тоот тушаалыг хүчингүй болгосугай.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
Ц.АДЪЯАСҮРЭН**

**ЭРҮҮЛ МЭНД,
Л.ЗОРИГ**

1997 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр улсын бүртгэлийн
1079 дугаарт бүртгэсэн.

**Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1997 оны 143/А/352
тоот тушаалын 1-р хавсралт**

УСНЫ НӨӨЦИЙГ БОХИРДЛООС ХАМГААЛАХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдлоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд энэхүү дүрмийн зорилго оршино.

2. Энэ дүрмийг хот төлөвлөлт, усны барилга байгууламжийн зураг, төсөл боловсруулах үе шатанд, түүнчлэн Монгол улсын нутаг дэвсгэрт бүх төрлийн зориулалтаар ус ашиглаж байгаа болон ашиглахаар төлөвлөж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
3. Усны байгалийн шинж чанар, найрлага өөрчлөгдөж хүний эрүүл мэнд, мал, усны амьтан, ургамал өсөн үржих хэвийн нөхцөл алдагдах, ус ашиглалтын шаардлага хангахгүй болох зэргийг усны бохирдлын шалгуур үзүүлэлтээр авч үзнэ.
4. Усны объектод ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний хаягдал бохир усыг цэвэршүүлэлгүйгээр нийлүүлэхийг хориглоно.
5. Газрын доорх чанар сайтай цэнгэг ус болон цэврийн зэргийн ангиллаар маш цэвэрт хамрагдах гадаргын усны объектыг унд ахуйн ус хангамжийн зориулалтаар ашиглах бөгөөд түүнд бохирдолтой ус нийлүүлэх, бохирдуулахыг хориглоно.
6. Томоохон хот суурингийн үерийн усны суваг, хоолойгоор дамжих хур тунадасны усыг хаягдал усанд тооцож цэвэршүүлж байж усны объектод нийлүүлнэ.

Хоёр. Гадаргын усыг бохирдохоос хамгаалах

7. Гадагш урсацгүй нуур, усан сан, цөөрөмд аливаа хаягдал ус нийлүүлэхийг хориглоно.
8. Гадаргын ус болон хамгаалалтын бүсэд дараах бохир ус, шингэнийг цэвэрлэж, халдваргүйтгэлгүйгээр хаяхыг хориглоно:
 - 1/ үйлдвэрийн болон ахуйн бохир ус;
 - 2/ нефть, нефтийн бүтээгдэхүүн, химийн хорт бодис агуулсан аливаа шингэн;
 - 3/ чанар, найрлага нь тодорхойгүй аливаа бодис.
9. Ашигт малтмал олдворлолтоос гарсан буюу, элс, хайрга угаасан усыг, түүн дэх жинлэгдэх бодисын хэмжээг 100 мг/л-ээс ихгүй болтол тунгаасны дараа гадаргын усанд нийлүүлнэ.
10. Усны тухай хуулийн 13-р зүйлийн 2-т заасны дагуу хамгаалалтад авсан усны объектод цэвэршүүлээгүй буюу дутуу цэвэршүүлсэн хаягдал ус, аливаа хог хаягдал болон усны экологийн нөхцөлийг алдагдуулах шинж чанар бүхий бодис, бүтээгдэхүүн оруулахыг хориглоно.
11. Усны объектод хаягдал ус оруулж байгаа буюу оруулах хэсгээс доош орших ус ашиглалтын эхний цэг дэх усны чанарт гарах өөрчлөлт нь гадаргын усны чанарын нийтлэг норм, шаардлагад тохирсон байна.

Гурав. Газрын доорх усыг бохирдлоос хамгаалах

12. Газрын доорх ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өрөмдмөл, уурхайн худаг, тохижуулсан булгийн усыг бохирдохоос хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ усны түвшин, ундарга, чанар, найрлагад байнгын ажиглалт, шинжилгээ хийж байна.
13. Сум, дүүрэг, багийн Засаг дарга нийтийн эзэмшлийн уст цэг, энгийн уурхайн худгийн усыг аливаа бохирдлоос хамгаалж таглах, эргэн тойрныг засаж тохижуулах эзэнтэй болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
14. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглалтын явцад газрын доорх ус, булгийн усны түвшин, ундарга, чанар, найрлага өөрчлөгдсөнөөс хойш 5 хоногийн дотор тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагад мэдэгдэж, нөхцөл байдлын шалтгааныг тогтоолгон, арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

15. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашигт малтмал олборлох, хөрс хуулах, өрөмдлөг хийх зэрэг хөрсний усны түвшин, чанарт нөлөөлөх үйл ажиллагаа эрхлэхийн өмнө тухайн нутаг дэвсгэрийн Засаг дарга болон байгаль орчны хяналтын байгууллагад мэдэгдсэн байна.

16. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага урьдчилан цэвэршүүлсэн хаягдал бохир ус ба хатуу хог хаягдлыг хөрсөнд хаях, хөрсөөр дамжуулан цэвэршүүлэхдээ газрын доорхи уст үеийг хамгаалах нөхцөлийг геологи хайгуулын болон байгаль орчин, эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагаар урьдчилан хайгуул судалгаа хийлгэж дүгнэлт гаргуулсан байна.

Дөрөв. Усны нөөцийг химийн болон цацраг идэвхт бодисоор бохирдохоос хамгаалах

17. Химийн хорт бодис, нефтийн бүтээгдэхүүн агуулсан аливаа шингэнийг хадгалах, түгээн дамжуулах барилга байгууламжийг барьж ашиглахдаа газрын хөрс, орчинд алдахгүй байх хамгаалалтын арга хэмжээг авч мэргэжлийн байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргасны дараа байнгын ашиглалтад оруулна.

18. Нефть, нефтийн бүтээгдэхүүн, химийн хорт бодис хадгалдаг, түгээн дамжуулдаг иргэн, аж ахуйн нэгж байгууллага хөрс, газрын доорх усны чанарт байнгын хяналтыг өөрийн хөрөнгөөр тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд хяналтын цооног гарган ашиглаж болно.

19. Химийн болон цацраг идэвхт бодис хэрэглэх үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хаягдал ус цэвэршүүлэх байгууламжийг цацраг идэвхжил сулруулах болон арилгах төхөөрөмжөөр тоноглоно.

20. Химийн болон цацраг идэвхт бодис агуулсан хаягдал усыг төв суурингийн бохир ус татуургын системд оруулах нөхцөлийг эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын болон цацрагийн аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

21. Усны объектод байх химийн болон цацраг идэвхт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг улсын цацрагийн, эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын болон Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны тэв байгууллага тогтооно.

22. Химийн хорт болон цацраг идэвхт бодис агуулсан бохир ус, хаягдлыг хоргүйжүүлэхэд үүссэн тунадас, өтгөрөл ихтэй үлдэгдлийг усны объект, ариутгах татуургын систем, хөрсөн дээр хаях, хөрсөнд булахыг хориглоно.

23. Химийн хорт болон цацраг идэвхт бодисын үлдэгдэл агуулсан ус хаягдлыг шинжилж цацраг идэвхжлийн агууламж, хэмжээг харгалзан уст үе, хөрсний ус үл нэвчих хөрсөнд 5 метрээс доош гүнд уг бодис алдагдахааргүй тусгайлан бэлтгэсэн саванд хийж тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн хяналтын байгууллагад бүртгүүлэн булшилна.

Тав. Хаягдал усыг усны объектод оруулах техникийн нөхцөл

24. Үйлдвэр, аж ахуйн бохир усыг "Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих үндсэн шаардлага" (MNS 4288-95)-ыг хангасан цэвэрлэх байгууламжид ариутгаж цэвэршүүлнэ.

25. Иргэн аж ахуйн нэгж, байгууллага хаягдал бохир усаа цэвэрлэх байгууламжид цэвэрлэх боломжгүй буюу ус ашиглалтын технологийн дагуу цэвэршүүлэх барилга байгууламжтай байх шаардлагагүй тохиолдолд Байгаль орчны, Дэд бүтцийн хөгжлийн, Эрүүл мэндийн сайдын 1995 оны хамтран баталсан "Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам"-ын дагуу шийдвэрлэнэ.

26. Бохир усны ариутгах татуурга болон цэвэршүүлэх, хоргүйжүүлэх, халдваргүйтгэх төхөөрөмжийн зураг төслийг боловсруулахдаа дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

1/ хаягдал усыг нийлүүлэх усны объектын урсац, горим, усны чанар, хаягдал ус нийлүүлж буй цэг, түүнээс дээших болон дооших хэсгийн ариун цэврийн нөхцөл;

2/ усны объектын ашиглалтын хэтийн төлөвтэй уялдуулах.

27. Бохир усны ариутгах татуурга болон цэвэршүүлэх, хоргүйжүүлэх, халдваргүйтгэх төхөөрөмжийн төслийн хүч чадлыг хаягдал усны төслийн дундаж хэмжээнээс 20 хувиар илүү, байнгын нөөцтэй байхаар тооцоолно.

28. Үйлдвэрийн газрын бохир усны систем, цэвэршүүлэх, халдваргүйтгэх төхөөрөмж, барилга байгууламжийг орон нутгийн нөхцөл, боломжтой уялдуулан доорх шаардлагыг харгалзан шийдвэрлэнэ:

1/ төв суурин, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын хаягдал усыг хамтатган цэвэршүүлэх;

2/ тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний хаягдал усыг зэргэлдээ орших бусад үйлдвэрийн хаягдал устай хамтатган цэвэршүүлж зайлуулах;

3/ тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний хаягдал усыг эргүүлэн ашиглах, цэвэршүүлэх, хоргүйжүүлэх, халдваргүйтгэх явцад аливаа бодисыг тусгайлан ялгаж авахад дөхөмтэй тохиолдолд түүнийг дангаар нь цэвэршүүлэх.

29. Бохир усан дахь нян устгагч, бусад хорт бодисын хэмжээ нь төв суурингийн бохир ус татуургын системийн төлөвлөлтийн ариун цэвэр, техникийн нөхцөл, норм, шаардлагад тохирч, биологийн цэвэрлэгээнд нөлөөлөхгүй тохиолдолд ахуйн болон үйлдвэрийн бохир усыг биологийн аргаар хамтатган цэвэршүүлнэ.

30. Үйлдвэрийн хаягдал усны хэмжээ, найрлага, тогтмол бүс ихсэж буурах, тохиолдолд биологийн цэвэрлэх байгууламж бүхий бохир усны ариутгах татуургын систем, цэвэрлэх байгууламж, усны объектод хэмжээ, найрлагаар хэвийн жигд урсган оруулах нөхцөлийг хангасан тусгай сан, жигдрүүлэх байгууламжийг барьж ашиглана.

31. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг засварлах хугацаанд болон аваар ослын үед бохир усыг усны объект, ариутгах татуургын нэгдсэн системд тусгай хуримтлуулагч санд объект нөөцлөн цэвэршүүлж байж нийлүүлнэ.

32. Усны объектод хаягдал ус нийлүүлэх цэгийг усны давалгаа, салхины хүчээр ус буцаж хөөгдөх нөхцөл байдлыг харгалзан, урсгалын дагуу хүн амын оршин суух бүс буюу төв суурин газар, ус ашиглалтын цэгээс доош сонгож тогтооно.

33. Тогтмол бус горимоор ажилладаг усан цахилгаан станцын далангийн хаалтын доод хэсэгт хаягдал ус нийлүүлэхдээ станцын ажиллагааны горим эрс өөрчлөгдөх эсхүл түүний ажиллагааг зогсоох үед усны буцах урсгалын нөлөөгөөр хаалтаас дээш орших ус ашиглалтын цэгт усыг бохирдуулахгүй байх нөхцөлийг хангасан байна.

34. Хаягдал ус зайлуулах систем нь ус хэмжих хэрэгсэл, шинжилгээний сорьц авах зориулалтын төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

35. Бохир усыг энэ дүрмийн шаардлагад нийцэхээр цэвэршүүлэх, халдваргүйжүүлэх, хоргүйжүүлэх үндэслэл, шаардлагыг тодорхойлохдоо ус ашиглалтын хяналтын цэгт усны объект хаягдал устай холилдох нөхцөл, шингэрэх хэмжээг тогтоосон туршилт тооцоо хийсэн байна.

36. Ус ашиглалтын хяналтын цэгт усны объект хаягдал устай холилдон шингэрэх хэмжээг тодорхойлохдоо энэ дүрмийн 26.28 дугаар зүйлийн шаардлагыг харгалзан дараах зарчмыг баримтална.

1/ усны объект болон түүнд нийлүүлж байгаа хаягдал усны цэгийн дундаж өнгөрөлт:

2/ гадаргын усны урсацын 95 хувийн хангамж бүхий жил, сарын цэгийн дундаж өнгөрөлт:
3/ урсацын зохицуулалт хийх усны урсацад ус боох далангийн хаалтын доод мөргөцөгт усны буцах урсгалгүй болох тохиолдолд урсац зохицуулах хаалтаас дооших хэсгийн усны баталгаат өнгөрөлт:

37. Урсгал усны гачиг үеийн урсацгүй байх хугацаанд хаях усыг тусгай санд хуримтлуулан хэвийн урсацтай болсны дараа энэ дүрмийн шаардлагыг баримтлан жигд юүлнэ.

38. Ус багатай жилийн гачиг үед хаягдал ус оруулах нөхцөлийг эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалах хяналтын байгууллага тогтооно.

39. Усны объектод хаягдал ус оруулах цэг нь төв суурин болон ус ашиглалтын эхний цэг орчимд орших тохиолдолд хаягдал усны чанар, найрлага нь ус ашиглалтын эхний цэгийн усны чанарын норм, шаардлагад нийцэж байх ёстой.

Зургаа. Усны объектод хаягдал ус оруулах нөхцөлийг зөвшөөрөлцөх.

40. Усны объектод хаягдал ус оруулах зөвшөөрлийг байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн ажиллаж байгаа үйлдвэр, аж ахуйн газарт 3 жилийн, ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа бол 2 жилийн хугацаатайгаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга олгоно.

41. Зөвшөөрлийн хугацаанд ус хэрэглээ нэмэгдэх буюу хаягдал усны хэмжээ, найрлага өөрчлөгдвөл тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн аж ахуйн нэгж байгууллагын хаягдал усыг гадаргын усанд оруулах нөхцөлийн талаар байгаль орчны болон эрүүл мэндийн мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг даргын шийдвэр гаргуулна.

42. Усны объектод хаягдал ус оруулах нөхцөлийн талаар дараах үеүдэд байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагаас зөвшөөрөл авна. Үүнд:

1/ усны чанарт нөлөөлөх үйлдвэр, объектыг өргөтгөх, үйлдвэрлэлийн технологийн өөрчлөлт, шинээр байгуулах объектын байршлыг тогтоож, барих талбайг сонгон авахад;

2/ шинээр барих, өргөтгөх, шинэчлэх үйлдвэр объектоос гарах бохир усыг цэвэрлэх, хоргүйжүүлэх, халдваргүйтгэх төхөөрөмжийн зураг төсөл болон ажиллаж байгаа үйлдвэр, объектын хаягдал усыг усны объектод оруулж байгаа нөхцөл нь энэ дүрмийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянаж магадлахад;

43. Шинээр барих, өргөтгөх, шинэчлэх үйлдвэр, объектын байршлыг сонгох үед хаягдал ус зайлуулах нөхцөлийг тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагаас зөвшөөрөл авахдаа дараах материалыг бэлтгэнэ:

1/ үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хүч чадал, хаягдал усны хэмжээ түүний найрлага дахь бохирдуулагч бодисын хэмжээ, хаягдал усыг цэвэршүүлэх, түүнээс хаягдлыг ялган авах зохистой аргууд холбогдох бусад материал

2/ хаягдал ус оруулах цэг, тухайн усны объектын ариун цэврийн байдал, ус зүйн болон гидрогеологийн горим, энэ хэсгийг ашиглах хэтийн төлвийн тухай материал

44. Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан /цаашид "Зөвшөөрөл олгогч албан тушаалтан" гэнэ/ нь зөвшөөрөл олгохдоо дээр дурьдсан материалаас гадна орон нутгийн нөхцөл байдал, хаягдал усны хэмжээ, найрлагатай холбогдсон нэмэлт материал, үндэслэлийг гаргуулж болно.

45. Зөвшөөрөл олгогч албан тушаалтан зураг төслийг хянахдаа тухайн объектын байршил, сонголтын урьдчилсан төслийг хэлэлцэн тавьсан шаардлага болон бохир ус цэвэрлэн зайлуулах нөхцөлийн биелэлттэй холбогдсон асуудлыг хянан үзнэ.

46. Техникийн зураг төслийг боловсруулах үе шатанд урьдчилан зөвшөөрөлцсөн материалуудад тусгагдаагүй асуудал гарвал зураг төсөлд тусгуулж энэ тухай тодорхой тайлбар хийлгэнэ.

47. Усан замын тээвэр хийх ажил үйлчилгээ эрхлэхэд объектыг хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1/ усан замын тээврийн хэрэгслээс гарах бохир ус, хаягдлыг агуулах, цэвэрлэхэд зориулсан төхөөрөмж, байгууламжийг усны зах, эрэгт хамгаалалтын бүсээс гадагш байршуулах:

2/ усан замын тээврийн хэрэгслээс гарах бохир ус болон усны гадарга дээрх хаягдлыг цэвэрлэж зайлуулах, дамжуулах хоолой, агуулах савнаас усанд нефть алдагдахаас хамгаалахад зориулсан төхөөрөмж, байгууламжтай байх:

Долоо. Хаягдал ус цэвэршүүлэх ажиллагаанд хяналт тавих

48. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хаягдал ус цэвэршүүлэх төхөөрөмж% байгууламжийн ашиглалтад дараах хяналтыг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ:

1/ цэвэрлэх, хоргүйжүүлэх байгууламжид ирж буй хаягдал усны найрлагад хяналт тавьж, байнгын шинжилгээ хийх:

2/ цэвэрлэх, хоргүйжүүлэх, халдваргүйжүүлэх байгууламжийн эцсийн дамжлагаар цэвэршин гарч буй усанд байнга шинжилгээ хийх:

3/ усан сан, урсгал усанд хаягдал ус орж байгаа цэгээс дээш болон доош орших байнгын шинжилгээ хийх:

49. Ус ашиглагч байгууллага нь орон нутгийн нөхцөл, усны объектын ашиглалтын байдал, хаягдал усны хор хохирол, цэвэршүүлэх байгууламжийн төрөл, хүч чадлыг харгалзан дотоодын хяналт тавих, үр дүнг мэдээлэх талаар аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргатай зөвшилцөн гэрээ байгуулна.

50. Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар судлалын асуудал эрхэлсэн албан тушаалтан дараах тохиолдолд хаягдал усыг усны объектод оруулахыг зогсоох, түүний найрлага дах бохирдуулах бодисын хэмжээг багасгах шаардлага тавих, ашиглалтыг түдгэлзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1/ ус ашиглалтын цэгт усны чанарын үзүүлэлтүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн

2/ усны объектод байх хорт бодис нь зөвшөөрөх хэмжээнээс хэтэрсэн:

3/ усны объектод хаягдал ус оруулсны улмаас усны экологийн тогтолцоо алдагдаж, хүн амын эрүүл мэндэд нөлөөлж, загас, амьтан ургамал хөнөөгдсөн нь тогтоогдвол:

Найм. Дүрэм зөрчигчдөд хүлээлгэх үүрэг, хариуцлага

51. Энэхүү дүрмийг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Монгол улсын "Эрүүгийн тухай хууль", "Байгаль хамгаалах тухай", "Усны тухай" хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1997 оны 143/А/352

тоот тушаалын 2-р хавсралт

**УНД АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ УСНЫ ОБЪЕКТЫН УСНЫ ЧАНАРЫН НОРМ,
ШААРДЛАГА**

Ус ашиглалтын төрөл

Усны объектын усны чанар, найрлаган үзүүлэлтүүд

Унд-ахуйн төвлөрсөн ба төвлөрсөн бус усан хангамж, мөн хүнсний үйлдвэрийн усан хангамжид ашиглах

Хүн амын амралт, зугаалга, спортод ашиглаж байгаа буюу ашиглах тэрчлэн хот, суурингийн дүүрэгт оршдогийнх нь хувьд ашиглах

1

2

3

1. Умбуур бодис

2. Хөвөгч хольцууд

3. Үнэр, амт

4. Өнгө

5. Температур

6. Устөрөгчийн илтгэгч /урвал/ PH

7. Эрдсийн бүрэлдэхүүн

8. Ууссан хүчилтөрөгч

Дор заасан хэмжээнээс илүүгээр нэмэгдэхгүй байвал зохино,

0,25 мг/л 0,75 мг/л

Усны зарцуулга гачиг байх үед байгалийн гаралтай эрдэс бодисуудыг 30 мг/л-ээс ихээр агуулсан усны объектод умбуур бодисын хэмжээг 5 хүртэл хувиар ихэсгэж болно. Урсгал ^санд 0,4 мм/сек, урсгалгүй тогтонги буюу хиймэл усан сангийн усанд 0,2 мм/сек-ээс илүү хурдтай тунах чанарын зүйл агуулсан хаягдал ус оруулахыг хориглоно.

Усны объектын гадаргууд өрөмтөх, /бодисууд/ нефтийн толбо үүсэж солонгорох ба бусад хольцууд бөөгнөрч хөвөх зэрэг өөрчлөлт гарахгүй байна.

Хаягдал усыг хлороор халдваргүйтгээд буюу халдваргүйтгэл хийлгүй усны объектод оруулахад үнэр, амт нь 2 баллаас хэтрэхгүй байна. Хаягдал ус нь загасны маханд гажууд үнэр, амт оруулахгүй байх ёстой.

Усан баганын доорх өндөрт мэдэгдэхүйц өнгө илрэхгүй байх ёстой.

20 см-т 10см-т

Хаягдал ус оруулснаас усны объектын усны температур нь сүүлийн 10 жилийн зуны хамгийн халуун байх үеийн сарын дундаж температураас 3°C-аас илүүгээр нэмэгдэхгүй байна

6,5-8,5 6,5-8,5 байна.

Хуурай үлдэгдэл 800 Амт нь 2 мг/л

түүний дотор: баллаас

хлорлог-300мг/л, бага байна.

сульфат-400 мг/л-ээс

хэтрэхгүй байна.

Жилийн аль ч улиралд өдрийн 12.00 цагаас өмнө авсан сорьцод 4 мг/ O₂-ээс багагүй байна

9. Хүчилтөрөгчийн биохимийн хэрэгцээ /ХБХ20 /

10. Өвчин үүсгэгчид

11. Хорт бодисууд

20°C-т дор заасан хэмжээнээс бага
3,0 5,0

Ус нь өвчин үүсгэгч нян агуулаагүй байх ёстой. Өвчин үүсгэгч нян агуулсан хаягдал усыг зохих цэвэрлэгээ хийсний дараа заавал халдваргүйтгэнэ. Биологийн цэвэрлэгээ хийгдсэн ахуйн бохир усыг нэг литр усанд гэдэсний таныц /колийн индекс/-ийг 1000-аас цөөн болтол нь 1,5 мг/л-ээс багагүй үлдэгдэл хлортой байхаар тооцож халдваргүйтгэн өвчин үүсгэгчгүй болгоно.

Хүн амын эрүүл мэнд, бие махбодид шууд ба шууд бусаар хор нөлөө үзүүлэх хэмжээгээр агуулагдаж болохгүй.

Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1997 оны 143/А/352 тоот тушаалын 3-р хавсралт

ГАДАРГЫН УСНЫ ЦЭВРИЙН ЗЭРГИЙН АНГИЛЛЫН НОРМ

Усны чанарын ангилал

№	Ангиллын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	I маш цэвэр	II цэвэр	III бохирдолт багатай	IV бохирдолтой	V их бохирдолтой
A		1	2	3	4	5	6
A. Хүчилтөрөгчийн горимын үзүүлэлтүүд:							
1	Ууссан хүчилтөрөгч	м/г	9<	8	6	4	<4
Шөнө ба өглөөний 9.00 цагаас эрт авсан сорьцод хийсэн тодорхойлолт хамаарахгүй.							
2	Хүчилтөрөгчийн ханамж	хувь	<90	75	60	40	<40
3	Хүчилтөрөгчийн биохимийн хэрэгцээ /ХБХ20/	м/г/о2/л	<3	5	10	15	15<
4	Хүчилтөрөгчийн химийн хэрэгцээ /XXX/	"-	<10	15	25	50	70<
5	Исэлдэх чанар	"-	<3	5	10	20	30<
6	Хүхэр устөрөгч /H2S2/	"-	илрэхгүй		0,1	1,0	1,0<

Б. Эрдсийн бүрэлдэхүүний үзүүлэлтүүд:

7 Нийт хатуулаг	Н	<10	15	20	30	40<
8 Кальцийн ион /CA2 ⁺ /	мг/л	<45	90	150	200	300<
9 Магнийн мон /Мд2ү	-".	<15	30	50	100	200<
10 Ууссан бодисуудын хуурай үлдэгдэл	мг/л	<200	300	500	80С	1200<
11 Хлорын ион /Сг/	-"-	<50	150	250	35С	500<
12 Сульфатын ион /SO24/	-"-	<50	100	200	300	400<

В. Шим бохирдлын үзүүлэлтүүд:

13 Аммонийн азот (NH4 ⁺)	мг/л	<0,02	0,05	0,1	0,3	0,5<
14 Натрийн азот (NO2 ⁻)	мг/л	<0,002	0,005	0,02	0,05	0,1<
15 Нитрат азот (NO3)	мг/л	<1	3	5	10	20,0<
16 Шим азот	мг/л	<0,3	0,5	1,0	2,0	2,0<

Г. Тусгай үзүүлэлтүүд:

17 Устөрөгчийн илтгэгч /РН/	мг/л	6,5-8,0	6,5-8,5	6,0-8,5	6,0-9,0	5,5-9,5
18 Нийт төмөр /Fe3+Fe2+/	мг/л	<0,3	0,5	1,0	1,5	1,5<
19 Марганц /Mn2+/	мг/л	<0,05	0,1	0,3	0,8	1,5<
20 Фенол	мг/л	Илрэхгүй	0,001	0,002	0,005	0,01<
21 Фосфатууд /PK43-/	мг/л	<0,02	0,05	0,1	0,5	0,5<
22 Нийт фосфер /PO43-/	мг/л	<0,025	0,1	1,0	2,0	2,0<
23 Гадаргуугийн идэвхт угаагч бодисууд /ГИУБ/	мг/л	Илрэхгүй	<0,1	0,5	1,0	1,0<
24 Нефть, нефтийн бүтээгдэхүүн	мг/л	Илрэхгүй	<0,05	0,1	0,3	0,5<
25 Өөх тос	Чанар	-"-	Илрэхгүй	Усны гадаргуу дээр өрөмтөж үзэгдэх ёсгүй.		

Д. Мэдрэмжлэгдэхүйц физик үзүүлэлтүүд:

26	Үнэр амт	Чанарын үнэлгээгээр	гаж үнэр, амтгүй	Мэргэжлийн хүнд мэдэгдэх төдий	Мэдрэгдэхүйц үнэр амттай	-"-
27	Өнгө	Чанарын үнэлгээгээр	өнгөгүй	өнгөгүй	Үл мэдэг Мэдэгдэхүйц	-"-

28Тунгалаг /шрифтээр/	См	35<	30	25	20	<20
29Умбуур бодис /хур тунадас багатай үед/	мг/л	10<	20	50	100	100<
Е. Бактер судлалын үзүүлэлтүүд:						
30Колийн титр	-	>10	1,0	0,1	0,01	<0,01
31Эмгэг төрүүлэгч нян	-	байх ёсгүй.	байх ёсгүй	Байх ёсгүй	Байх ёсгүй	Байх ёсгүй
32Микробын ерөнхий тоо		<5.105	106	3.106	5.106	5.106<
Ж. Хорт бодисууд						
33Цианидын ион /CN-/	Мг/л	Илрэхгүй	Илрэхгүй	<0,01	0,05	0,1<
34Мөнгөн ус /Hд2+/Hg2+/	-"	-"	-"	0,001	0,005	0,005<
35Хүндэл /As3- +Ass+/	-"	-"	0,01	0,02	0,05	0,05<
36Фтор /F-/	-"	0,2	0,5	1,0	1,5	1,5<
Зөвхөн газар тариалан услахад						
37Бор /B/	-"	Байх ёсгүй	-"	0,5	1,0	<1,0
38Селен /Se2+/	-"	Илрэхгүй	0,01<	0,05	0,1	<0,1
/Зөвхөн газар, тариалан услахад/						
39Цайр /Zn2+/	-"	<0,2	1,0	2,0	5,0	5,0<
40Банадий /w/	-"	<байх ёсгүй	байх ёсгүй	байх ёсгүй	<1,0	1,0<
41Зэс /Cu2+/	-"	<0,01	0,05	0,1	0,5	0,5<
42Зөөлөн цагаан /Cd2+/	-"	Илрэхгүй	0,005	0,01	0,1	0,1<
43Албин /Co2+/	-"	<0,01	0,02	0,05	0,1	1,0<
44Анзан /Mo2+/	-"	<0,001	0,1	0,5	1,0	1,0<
45Мөнгө /Ag+/	-"	<0,001	0,01	0,02	0,05	0,05<
46Диц /Ni2+/	Мг/л	<0,01	0,05	0,1	0,2	0,2<
47Сульфат ион	-"	<илрэх ёсгүй	Илрэх ёсгүй			
48Хар тугалга /Pb2+/	-"	<0,01	0,05	0,1	0,2	0,2<
493 цэнэгт хорм /Cs3+/	-"	Илрэх ёсгүй	0,2	0,1	0,5	0,5<
506 цэнэгт хорм /C46+/	-"	Илрэх ёсгүй	0,01	0,05	0,1	0,1<
51Чөлөөт хлор /Cl/	-"	0,0	0,0	0,0	0,5	0,1<
3. Сапроб чанар						
52Пантле-Букийн таньц /индекс/	-"	<1,0	1,5	2,0	2,5	2,5<

53Сладчекийн ангилал	-"-	Ксено /х/	Олиго /О/	Олиго -бета -мозо /0-b-m/	-альфа -мезо (a-m)	Цали /P/
-------------------------	-----	--------------	--------------	------------------------------------	--------------------------	-------------

Тайлбар -*шинжилгээний хамгийн мэдрэмтгий нарийн аргаар тодорхойлоход илрэхгүй байх ёстой.

Байгалийн хүчиллэг, тэрчлэн эрдэсжилт ба хатуулаг ихгүй ус нь гадаргын усны цэврийн зэргийн дээрх ангилалд хамаарагдахгүй.

Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1997 оны 143/А/352 тоот тушаалын 4-р хавсралт

ГАДАРГЫН УСНЫ ЦЭВРИЙН ЗЭРГИЙН АНГИЛЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

1. Маш цэвэр ус-Энэ ангийн усыг ариун цэврийн хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нөхцөлд ус ашиглалтын бүх төрөлд ашиглахад тохирох боловч нэн тэргүүнд унд-ахуйн төвлөрсөн ба төвлөрсөн бус усан хангамжийн хэрэгцээнд шууд буюу зөвхөн халдваргүйтгээд ашиглана.
 2. Цэвэр ус- Энэ ангийн усыг тусгайлан өндөр шаардлага тавигдахгүй нөхцөлд ус ашиглалтын бүх төрөлд түүний дотор загасны аж ахуйн ус ашиглалтын нэгдүгээр төрөлд ашиглахад тохирох бөгөөд унд-ахуйн төвлөрсөн ба төвлөрсөн бус усан хангамж хүнсний үйлдвэрийн хэрэгцээнд зөвхөн халдваргүйтгээд шууд буюу тунгааж шүүж, халдваргүйтгэн ашиглана.
 3. Бага бохирдолтой ус- Энэ ангийн ус нь нийтийн унд- ахуйн усан хангамж, үйлдвэрийн хэрэгцээнд зарим талаар тохирохгүй боловч ариун цэврийн хамгаалалтын арга хэмжээг чанд хэрэгжүүлсэн нөхцөлд зохих цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийгээд ашиглаж болох бөгөөд загасны аж ахуйн ус ашиглалтын хоёрдугаар төрөл болон малын унд, хүн амын амралт, зугаалга, биеийн тамир спортод ашиглаж болно.
 4. Бохирдолтой ус- Энэ ангийн усыг газар тариалангийн усалгаанд, тэрчлэн тунгаах, шүүх, зөөлрүүлэх зэргээр урьдчилсан боловсруулалт хийгээд зарим үйлдвэрлэлийн техникийн усан хангамжийн хэрэгцээнд ашиглана. Нефть, тоо, фенол, химийн бусад хорт бодис, устөрөгчийн илтгэгч (РН) зэргийг нарийвчлан шинжилж тодорхойлон судалсан нөхцөлд загасны аж ахуйн зориулалтаар ашиглаж болно.
 5. Их бохирдолтой ус- Энэ ангийн усыг тунгаах, шүүх, зөөлрүүлэх зэргээр урьдчилан цэвэршүүлсэн нөхцөлд хүний шууд оролцоо шаардагдахгүй үйлдвэрлэлийн техникийн усан хангамжийн зарим хэрэгцээнд ашиглаж болно.
- Гадаргын усны цэврийн зэргийн дээрх нормд заасан хэмжээнээс хэтэрсэн чанар, найрлагатай усыг маш их бохирдолтой буюу зэрэглэлээс гадуур тооцох бөгөөд түүнийг ус ашиглалтын аль ч төрөлд ашиглах боломжгүй учир усны бохирдлыг арилган цэвэршүүлэх, нэмж бохирдох, хорогдохоос хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1997 оны 143/А/352
тоот тушаалын 5-р хавсралт

**УНД АХУЙН УС АШИГЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ УСНЫ ОБЪЕКТОД БАЙХ
ХОРТ БОДИСЫН ЗӨВШӨӨРӨГДӨХ дээд хэмжээ**

№	Бодисын нэр	ЗДХ мг(литрээф)
А. Хор нөлөөний ариун цэвэр-хордуулах чанарын хязгаардах чанарын хязгаарлах үзүүлэлтээр:		
1	Адипат натр	1
2	Адипины хүчлийн динитрил	0.1
3	Албин (CO ₂ +))	1
4	Акрилийн хүчил	0.5
5	Акрилийн хүчлийн нитрил	2
6	Анзан /Моь+/	0.5
7	Анизол	0.05
8	Анилин	0.1
9	Ацетонциангидрин	0.001
10	Ацетофенон	0.1
11	Бензол	0.1
12	Бензойн хүчлийн полихлор	5
13	Биндэр /Be ₂ +/	0.0001
14	Бор	0.5
15	Ванадий /V ₅ +/	0.1
16	Винилацетат	0.2
17	Висмут /Bi ₃ +/	0.5
18	Висмут /Bi ₀ +/	0.1
19	Вольфрам /W ₆ +/	0.1
20	Гексаген (циклотриметилен тринитромин)	0.1
21	Гексаметилендиамин	0.01
22	Гексанат	5
23	Гексахлорбензол	0.05
24	Гептахлор	0.05

25	Гөлтилийн спирт	0.005
26	Гербан	2
27	Гидразин	0.01
28	ДД	0.4
29	ДДТ	0.1
30	Дианат (2-метокон-3, 6-дихлор бензойн хүчил)	15
31	1.2-Дибромпропан (ДБП)	0.1
32	Дибутиламин	6
33	Диизооктилтиогликолят-дибутил цагаан тугалга (ДИОТГДБЦТ)	0.01
34	Диизопропиламин	0.5
35	м-диизоропилбензол	0.05
36	Диметил адипины хүчил	0.1
37	Диметиламин	0.1
38	Диметилдиоксан	0.0005
39	Диметилдитиокарбанат	0.5

40	Диметилфенилкарбонил	0.05
41	Динитродиэтиленгликоль	1
42	Динитротолуол	0.5
43	2.4 - Динитрофенол	0.03
44	1.2 - дихлордибутан	0.4
45	Дихлордибутил - цагаан тугалга	0.002
46	1.3 - дихлоризобутилен	0.4
47	2.3 - дихлор-1.4 - нафтахинон	0.25
48	1.2 - дихлорпропан	0.4
49	2.3 - дихлорпропилен	0.4
50	Дихлорфенилоксимочевин (ДХФМ)	0.8
51	Диц (N2)	0.1
52	Диэтиламин	2
53	Диэтиленгликоль	1
54	Диэтилдихлорид цагаан тугалга	0.02
55	Диэтил мөнгөн ус	0.0001
56	Изокротонитрил	0.1
57	Изопропиламин	2
58	Изопропил бензойны шингэн хэт исэл	0.5
59	Индотолуидын	1
60	/МД/- крезол (m,p - крезол)	0.004

61	Кретонитрил	0.1
62	Линурон	1
63	2.5 - Лутидин	0.05
64	Малейн хүчлийн диэтилийн эфир	1
65	Малоны хүчлийн малононитрил	0.02
66	Метакриламид	0.05
67	Метакрилын хүчил	1
68	Метанол	3
69	Метилацетат	0.1
70	Монобутиламин	8
71	Монометиламин	1
72	Моноэтаноламин	0.5
73	Мөнгөн ус	0.001
74	В - нафтол	0.4
75	Нитрат (азотын ионоор)	10
76	Нитрабензол	0.2
77	Нитропропан	1
78	М - нитрофенол	0.06
79	Н - нитрофенол	0.02
80	О - нитрофенол	0.06
81	Нитрохлорбензол	0.05
82	Нитрациклогексан	0.1
83	Нитроэтан	1
84	Нонилын спирт	0.01
85	Октоген	0.2
86	Парафенилендиамин (урсол)	0.1
87	Парахенондиоксим	0.1
88	Парахлорбензойны хүчил	5
89	Пентанат	2.5
90	Пента-эритрит	0.1
91	Перхлорт аммони	5
92	Пиконил	0.05
93	Пиперидин	0.06
94	Пиридин	0.2
95	Полиакриламид	2
96	Полихлорбензойны хүчил (2 Кф)	5
97	Полихлорпинен	0.2
98	Роданидууд	0.1
99	Сайфос	0.1
100	Селен (Sr2+)	0.01
101	Стронц (Sb2+) тогтвортой	2.0
102	Сурьма (S63+)	0.05
103	Теллур /Te 2+)	0.01
104	Тетрахлорбензол	0.01
105	Тетрахлорпропан	0.1
106	Тетрахлорт нүүрстөрөгч	0.3

107	Тетраэтил хар тугалга	байх ёсгүй
108	Тетраэтил цагаан тугалга	0.0002
109	Трибутилметакрилад-цагаан тугалга	0.0002
110	Трикрезилфосфат	0.005
111	Трифторхлорпропан	0.1
112	Трихлорбензойны хүчил	1
113	Триэтиламин	2
114	Триэтиленгликольдинитрат	0.1
115	Уротропин	0.5
116	Фенилгедразин	0.01
117	Ферроцианидууд	1.25
118	Флотороагент Т-66	0.2
119	Формальдигед	0.05
120	Фтор, түүний нэгдлүүд /F3-/	1.5
121	Фуран	0.2
122	Хартугалга /Pb2+/-	0.1
123	Хлораль	0.2
124	Хлоранилин	0.2
125	Хлорбензол	0,02
126	II-Хлорбензосульф хүчлийн натрийн давс	2
127	Хлорлог этилмеркур	0.0001
128	Хүнцэл /As3+/-	0.05
129	Цагууц натр /SiO3-аар/-	50
130	Цианидууд /CN-ээр/-	0.1
131	Цианлаг аллил	0.1
132	Циклогексан	0.1
133	Циклогексаноол	0.5
134	Циклогексанон	0.2
135	Циклогексаноноксим	1
136	Циклогексен	0.02
137	Эпихлоргидрин	0.01
138	Этиленгликоль	1
Б. Хор нөлөөний ерөнхий ариун цэврийн хязгаарлах үзүүлэлтээр		
1	Арезин	0.05
2	Атразин	0.5
3	Ацетон	ХБХ.ууссан хүчилтөрөгчийн үзүүлэлт болон усан сангийн усан дахь шим бодисын агууламжаар тооцсон зөвшөөрөх хэмжээнд байна.
4	Бензойны хүчил	— " —
5	Дибутилфенилфосфат	— „ —
6	Дибутилфталат	0.2
7	Дивиниладипат	0.2

9	Динитророданбензол	0.5
10	Диоктилфталат	1
11	Дифенилгу^нидин	1
12	Дихлорфенилфосфат	3,4-р бодистой адил
13	Зөөлөн цапаан /СИ2+/ Зэс /СИ2+;	0.01 0.1
15	Идэвхт хлор *	илрэхгүй
16	Изобутилацетат	3,4-р бодистой адил
17	Изобутилын спирт	1
18	Карбозан 0	1
19	Капррлактам	1
20	Метилпролидон	0.5
21	Монобутиламин	8
22	Моногедропрекись	0.6
23	Нийлэг өөхний хүчлүүд	3,4-р бодистой адил
24	Норсульфазол	1
25	Пропанид	0.1
26	Пропиленгликоль	3,4-р бодистой адил
27	Пропион хүчлийн натрийн давс	3,4-р бодистой адил
28	Рамрод	0.01
29	Резорцин	0.1
30	Стрептоцид	0.5
31	Сульгин	0.01
32	Сульфидууд *	илрэхгүй
33	Сульфодимезин	1
34	Сульфолен	0.1
35	Сүүний хүчил	3,4-р бодистой адил
36	Терефталын хүчил	0.1
37	Тетрагидрофурилын спирт	0.5
38	Титан /Ti4+/ Тосны (маслын) хүчил	0.1 3,4-р бодистой адил
40	Тринитротолуол	0.5
41	Трихлорацетат натр	5
42	Триэтиленгликоль	3,4-р бодистой адил
43	Фталын хүчил	0.5
44	Фенурон	0.2
45	Хөх будагч "З"	10
46	Цайр /Zn2+/ Хромолан	1 3,4-р бодистой адил
48	Цууны хүчил	3,4-р бодистой адил
49	Шоргоолжны хүчил	3,4-р бодистой адил
50	Шивтэр (N – азотоор)	2
51	Этиленгликолийн Моноэтиллэг эфир	1

В. Хор нөлөөний мэдрэмжлэгдэхүй хязгаарлах үзүүлэлтээр

1	Авадекс	0.03
2	Алдрин	0.002
3	Алкилбензолсульфонат (АБС)	0.5
4	Алкилбензолсульф хүчлийн аммонийн давс (АБСХАД)	0.8
5	Алкилбензолсульф хүчлийн кальцийн давс (АБСХКД)	0.2
6	Алкилбензолсульф хүчлийн триэаноламины давс (АБСХТЭД)	1
7	Алкилсульфатүүд	0.5
8	Алкилсульфонатууд	0.5
9	Алкомон ОС-20	0.5
10	Аллилын спирт	0.1
11	Альтакс	байх ёсгүй
12	п - Аминофенол	0.05
13	о - Аминофенол	0.01
14	АНП - 2	0.4
15	Антио	0.004
16	АПН	0.05
17	Ацетальдегид	0.2
18	Ацетонитрил	0.7
19	Ацетофос	0.03
20	Бари /Ba ²⁺ /	4
21	Бензин	0.1
22	Бензоат кали	7.5
23	Бутадиен	0.05
24	Бутилбензол	0.1
25	Бутилен	0.2
26	Бутилын ксантогенат	0.001
27	Бутилын спирт	1
28	Бутилын эфир	0.02
29	Бутилкрилат	0.015
30	Бутифос	0.0003
31	Винилсиликонат натр (ГКЖ-12)	2
32	Гадаргуун идэвхт бодис (ГИБ)	0.5
33	Гексахлорон	0.02
34	Гексахлорбутадиен	0.01
35	Гексахлорбутан	0.01
36	Гексахлорциклопентадиен	0.001
37	Гексахлорэтан	0.01
38	Гөксилур	0.2
39	Гептахлор	0.05
40	Гидрохинон	0.2
41	Давирхай	0.2
42	Далапо..	2

43	Дибутилдитиофосфорын кали	27
44	Дибутилмонотиофосфорын кали	0.1
45	Диизобутиламин	0.07
46	Диизопропилдитиофосфорын кали	0.02
47	Дикотекс	0.25
48	Дилор	0.1
49	Диметилдитиофосфорын хүчил	0.1
50	Диметилдихлорвинилфосфат (ДДВФ)	1
51	Диметилдисульфид	0.04
52	Диметилсульфид	0.01
53	Диметилтерефталат	1.5

54	Диметилфенол	0.25
55	Димид	4
56	Динитробензол	0.5
57	Динитронафталин	1
58	Динитрохлорбензол	0.5
59	Дипропиламин	0.5
60	Диурон	1
61	Дифенилолпропан	0.01
62	3.4 - дихлоранилин	0.05
63	2.5 - дихлоранилин	0.05
64	п - дихлорбензол	0.002
65	о - дихлорбензол	0.002
66	Дихлорбутан	0.05
67	Дихлорбутил	0.05
68	Дихлоргидрин	1
69	Дихлорметан	7.5
70	Дихлорфенол	0.002
71	Дихлорфено-цуун хүчлийн натрийн давс	1
72	Дихлорциклогексан	0.02
73	Дихлорэтан	2
74	Дицландиамид	10
75	Диэтанолламин	0.8
76	Диэтиламин (ДЭТА)	0.2
77	Диэтилбензол	0.04
78	Диэтилдитиофосфорын кали	0.5
79	Диэтилдитиофосфорын хүчил	0.2
80	Диэтилийн эфир	0.3
81	Жирийн нефть	0.3
82	Зэс/Cu ²⁺ /	1
83	Изобутилен	0.5

84	Изопрен	0.005
85	Изопропилийн спирт	0.25
86	Изопротилфенил - карбамат (ИФК)	0.2
87	Изопропилхлорфенил карбамат (хлор ИФК)	1
88	Калтакс	байх ёсгүй
89	Карбин	0.03
90	Карбофос	0.05
91	Керосин	0.1
92	Крезилийн дитиофосфат	0.001
93	Ксилол	0.05
94	Малейны ангидрид	1
95	Малейны хүчил	1
96	В - маркаптодиэтиламин	0.1
97	Меркаптофос	0.01
98	Метазин	0.3
99	Метакрилын хүчлийн бутилын спирт	0.02
100	Метафос	0.02
101	Метилакрилат	0.02
102	Метилацетофос	0.03
103	Метилбензоат	0.001
104	Метилдитиокарбамат (карбатион)	0.02
105	Метилмеркаптан	0.0002
106	Метилнитрофос	0.25
107	Метилсиликонат натр (ГКЖ-П)	2
108	Метилсистекс	0.01

109	- метилстирол	0.1
110	Метилэтилкетон	1
111	Милон	0.01
112	Моноалкилсульфоянтарын хүчлийн бинатрийн давс (ДНД)	0.5
113	Моноизобутиламин	0.04
114	Монопропиламин	0.5
115	Монохлоргидрин	0.7
116	Моноэтиламин	0.5
117	Монохлорпропионы хүчил	0.8
118	Монурен	5
119	Нафтейны хүчлүүд	0.3
120	а-Нафтол	0.1
121	Нитрометан	0.005
122	п - НитЕюфениламино/этанел (оксиамин)	0.5

123	п - Нитрофенилхлорчетил/карбинол (карбинол)	0.2
124	Нитроформ	0.01
125	О - диметил -S- этилмеркапто этилдитиофосфат (М-81)	0.001
126	Октанол	0,05
127	ОП -7	0.4
128	ОП -10	1.5
129	Паторан	0.2
130	Пентахлорбутан	0.02
131	Пентахлорпропан	0.03
132	Пентахлорфенол	0.3
133	Пентахлорфенолят натр	5
134	Пикрины хүчил	0.5
135	Пирогалол	0.1
136	Пирокетехин	0.1
137	Поликарбазин	2
138	Полиметилгидросилооксан (ГКЖ-94М)	2
139	Полиметилдихлорфенилсилоксан (ХС-2-1)	10
140	Полиэтилгидросилоксан _[ГКЖ-94)	10
141	Полиэтилсилоксан	10
142	Прометрин	3
143	Пропазин	1
144	Пропилбензол	0.2
145	Пропилен	0.5
146	Пропилийн спирт	0.25
147	Салицилын хүчлийн анилид	2.5
148	Сапонин	0.2
149	Севин	0.1
150	Симазин (уусаагүй]	байх ёсгүй
151	Стирол	0.1
152	Сульфенамид БТ	0.05
153	Сульфонал	0.5
154	Тетрагидрохинон	0.05
155	Тетранитрометан	0.5
156	Тетрахлоргептан	0.0025
157	Тетрохлорнонан	0.003
ГТ6Т	Тетрахлорпентан	0.005
159	Тетрахлорпропан	0.01
160	Тетрахлорт нүүрстөрөгч	5
161	Тетрахлорундекан	0.007
162	Тетрахлорэтан	0.2

163	Тиофен	2
164	Тиофос	0.003
165	Толуол	0.5
166	Төмөр /Fe3+/ 	0.5
167	Трибутилфосфат	0.01
168	Триксилинилфосфат	0.05
169	Трихлорбензол	0.03
170	Трихлорметафос-3	0.4
171	Трихлорфенол	0.004
172	Трихлорэтилен	0.5
173	Триэтаноламин	1.5
174	Фазолон	0.001
175	Фенол (карболын хүчил)	0.001
176	Фосбутил	0.03
177	Фосфамид	0.03
178	Фталофос	0.2
179	Фурфурол	1
180	Хлоранил	0.01
181	Хлорлог аллил	0.3
182j	Хлорнитрозоцеклагексан	0.005
183	Хлорофос	0
184	Хлорпелларгоны хүчил	0.3
